

## ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

### Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Ховд аймгийн Мөнххайрхан сумын төсөвт байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

### Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Бадрал, Ж.Цэнд-Аюуш, Улсын байцаагч Ц.Цэцэнхараацай, Д.Болормаа, П.Мягмартүвшин нар 2020 оны 09 сарын 28-наас 10 сарын 02-ны хооронд хяналт шалгалтаар ажиллав.

### Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

### Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын бусад хууль эрхзүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвөөс батлагдсан, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, эргэлтийн хөрөнгийг олж бэлтгэн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилттой ажиллаж иржээ.

Шалгагдах хугацааны хөрөнгийн эрх, захирагчийн нэгдүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Батболд, ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Түвшинзориг, ЗДТГ-ын дарга О.Бишгарам, Сургуулийн захирал Б.Батзаяа, Цэцэрлэгийн эрхлэгч У.Долгорсүрэн, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Энхбулган, Соёлын төвийн эрхлэгч Х.Мягмаржав, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Бадамцэцэг, М.Энхтуул, Л.Минжмаа нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, Санхүүгийн албаны дарга Э.Эрэндаваа, төрийн сангийн мэргэжилтэн Ш.Тогооч нар хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Бадрал Засаг даргын Тамгын газар, Улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш – Ерөнхий боловсролын сургууль, Улсын байцаагч Ц.Цэцэнхараацай - Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын байцаагч Д.Болормаа – Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Улсын байцаагч П.Мягмартүвшин – Цэцэрлэгийн баримтыг тус тус шалгалаа.

Тав. Төсвийн бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн талаар

Мөнххайрхан сум нь татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 2019 онд нийт 34.4 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 189.1 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 154.7 сая төгрөгөөр буюу 548.6 хувиар давуулан биелүүлжээ. Шалтгаан нь ангийн орлого төлөвлөгдөөгүй байсан бөгөөд тайлант онд ангийн орлогоор 152.0 сая төгрөг оруулсантай холбоотой байна.

2019 онд татварын орлого 30.8 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 186.7 сая төгрөг буюу 155.9 сая төгрөг, 604.8 хувиар, татварын бус орлого 3.6 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2.4 сая төгрөг буюу 1.2 сая төгрөгөөр тасарч, 66.7 хувиар биелүүлжээ.

Татварын орлогын төлөвлөгөөг төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Татварын төрөл	Мянган төгрөгөөр 2019 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Татварын орлого</b>	<b>30880.0</b>	<b>186787.2</b>
1.1	Орлогын албан татвар	8500.0	11692.6
1.2	Хөрөнгийн татвар	11000.0	13191.6
1.3	Бусад татвар, төлбөр, хураамж	11380.0	161903.0
<b>2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>3605.0</b>	<b>2405.0</b>
2.1	Торгууль	2000.0	800
2.2	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1605.0	1605.0
2.3	Хүүгийн орлого	0	0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>34485.0</b>	<b>189192.2</b>

### 5.1 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

#### Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2019 онд орон нутгийн төсвөөс 40674.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 40674.8 мянган төгрөг зарцуулжээ.

2019 онд цалин хөлсөнд 31678.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3959.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3526.1 мянган төгрөг, томилолт 389.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 207.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 715.0 мянган төгрөг, мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

2019 онд авлага, өр төлбөргүй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө 2019 оны эхэнд 8439.8 мянган төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст мөн 8896.8 мянган төгрөг болж, 457.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Санхүүгийн программын үнэ 457.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

#### Өмнөх шалгалтын талаар:

2019 онуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

#### Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй байна.

#### Дүгнэлт:

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэл хэвийн, анхан шатны баримтын бүрдэл хангалттай сайн явагдаж байна.

### 5.2 Засаг даргын Тамгын газар

#### Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2019 онд орон нутгийн төсвөөс 335747.9 мянган төгрөг, өөрийн орлогоор 605.0 мянган төгрөг, нийт 336352.9 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 335747.9 мянган төгрөг, өөрийн орлогоор 605.0 /зочид буудлын орлого 294.0 мянга, түрээс-240.0 мянга бусад орлого-71.0 мянга/ мянган төгрөг, нийт 336352.9 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Тус онд цалингийн зардалд 200530.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 25066.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 23759.8 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 3148.1 мянган төгрөг,

тээвэр шатахууны зардалд 13452.2 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 2215.0 мянган төгрөг, томилолтын зардалд 7041.8 мянган төгрөг, нормативт зардалд 402.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 3068.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 26508.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10431.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 220.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжинд 20509.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж ажилласан байна.

2019 онд өглөг, авлагагүй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 2693154.0 мянган төгрөг байсан бол оны эцэст 2447270.4 мянган төгрөг болж, 245883.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус онд 37691.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 242881.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 40692.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

2019 онд 273017.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, бүртгэсэн байна.

2019 онд Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 46 дугаар тогтоолоор 242881.8 мянган төгрөгийн хөрөнгийг актлах, 2019 оны 93 дугаар тогтоолоор 40692.9 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн Мал эмнэлэгийн газарт шилжүүлэх шийдвэр гаргасны дагуу тайлан тэнцэлд тусгажээ.

2019 онд УИХ-ын гишүүн О.Батнасангийн дэмжлэгээр Багийг чадавхижуулах пилот хөтөлбөрийн хүрээнд Иргэний танхим тохижуулах 10500.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орсноос тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгөнд 9854.0 мянган төгрөг, бараа материалд 245.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч, тээврийн зардалд 200.0 мянган төгрөгийг төлжээ.

Харин Мал эмнэлэгийн газарт шилжүүлэх 40692.9 мянган төгрөгийн хөрөнгөөс 18079.9 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй байсныг хандиваар бүртгэж, шилжүүлсэн байна.

2019 онд Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар:

- Шилдэг сумын шагнал-800000 төгрөг
- Мал тооллогын санхүүжилт-353619 төгрөг
- Орон сууц, хүн амын тооллого-1087500 төгрөг
- О.Батнасан гишүүний ажлын албанаас Багийг чадавхижуулах пилот хөтөлбөрийн хүрээнд -6400000 төгрөг
- О.Батнасан гишүүний ажлын албанаас Багийг чадавхижуулах пилот хөтөлбөрийн хүрээнд Иргэний танхим тохижуулах-10500000 төгрөг
- Тендерийн хураамж-247500 төгрөг

- Давсан орлого-293000 төгрөг, нийт 19681619 төгрөг бүрдүүлэн зарцуулжээ.

Өмнөх шалгалтын талаар:

Төрийн аудитын газраас тус байгууллагад 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар МЭУСАХЗ-ын тооцоогоор сумын Засаг даргын Тамгын газраас мал эмнэлэгийн нэгж “Цэнхэрийн долгио”, “Мөнххайрхан царцаа” ХХК-ниудад орон нутгийн төсвөөс 6.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 14 сая төгрөг авч, 7.3 сая төгрөгийн санхүүжилт илүү авсан, аймгийн мал эмнэлэгийн газраас 7.0 сая төгрөгийг авахаар тооцоо Аудитын газарт ирүүлж, 0.3 сая төгрөгийн хоорондын тооцоо дутуу байгааг илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

2016-2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт, шалгалт хийж, урамшуулал, цалин хөлс, албан томилолт зэргийг илүү тооцон олгосонтой холбоотой 4900.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, акт тогтоосон бөгөөд одоогийн байдлаар 206.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 12374.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авахдаа ИТХ-ын шийдвэргүйгээр авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг

2. 2019 онд 768000 төгрөгийн резинэн дугуйг автомашинд олгохдоо тооцоо бодож, норм тооцоогүй нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтыг

3. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 177300 төгрөгийг анхан шатны баримтгүйгээр няравын дансаар дамжуулан зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг

4. Жолооч Б нь замын хуудсыг буруу бичдэг, албан томилолтоор ажилласан хугацаанд заримдаа замын хуудас бичээгүй, зөрүүтэй бичсэн, албан томилолтоор Улаанбаатар хотод ажиллаж байгаа албан тушаалтныг хөдөө багаар ажиллаж байгаагаар хуурамчаар бичсэн зэрэгтэй холбоотой 177660 төгрөгийг шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын 6.4 дэх заалтыг

5. Төрийн сангийн мэргэжилтний үндсэн чиг үүрэгт хамаарах ажилд ажил хавсарсны нэмэгдэлд үндсэн цалингийн 20%-иар тооцон 2019 онд 1329000 төгрөг

олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 1.2.4 дэх заалтыг

6. Ня-бо Б-д 6 дугаар сард тушаал шийдвэргүйгээр 25%-иар тооцон 177426 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалтыг

7. ЗДТГ нь 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр трактор түрээслүүлэх гэрээг 2 иргэнтэй 540000 /2\*270000/ төгрөгийн төлбөр авахаар тохиролцон, халуун ус түрээслүүлэх гэрээг 1 иргэнтэй 270000 мянган төгрөгийн төлбөр авахаар тохиролцон байгуулсан бөгөөд тракторын төлбөрт 2019 онд 60000 төгрөг, халуун уснаас 180000 төгрөгийн орлого орсон, ажиллаагүй хугацааг тооцоогүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, түрээсийн төлбөрт тушаасан 60000 төгрөгийг анхан шатны баримтгүйгээр бэлнээр зарцуулсан нь Төрийн болон орон өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтууд, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6, 3.12 дахь заалтуудыг

8. 2019 онд Мэргэжилтэнд ээлжийн амралттай байхад 2 өдрийн цалин 71516 /750919\*2/21/ давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг тус тус зөрчжээ.

Шалгалтаар нийт 2760902 төгрөгийн төлбөр зөрчил илэрч, 768000 төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 1992902 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар шийдвэрлэж, улсын ахлах байцаагчийн 3 акт тогтоов.

#### Дүгнэлт:

Засаг даргын Тамгын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хэвийн, шатахууны тооцоо, анхан шатны баримт бүрдэл, тооцоо бодолт сул байна.

Төрийн өмч хөрөнгийг түрээсээр ашиглуулж байгаа тохиолдолд гэрээний үүргийг түрээслэгч талаас хангуулаагүй байна.

#### Цаашид авах арга хэмжээний санал

1. Засаг даргын нөөцөөс зарцуулж байгаа хөрөнгөд хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийж байх.

2. Автомашинд сэлбэг хэрэгсэл, дугуй олгохдоо норм тооцож, тооцоо бодсоны үндсэн дээр олгох, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөх.

3. Цалин хөлсийг хууль, эрх зүйн хүрээнд зөв бодож олгох.

4. Жолоочийн тооцоог нягтлан бодогч бодохдоо нягтлан шалгаж, бүрэн тулгасны үндсэн дээр бодох, замын хуудас хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна. Нярав шатахууны тайланг үнэн зөв гаргах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахад онцгой анхаарах шаардлагатай.

5. Төрийн өмч хөрөнгийг түрээслүүлэхдээ гэрээний үүргийг түрээслэгч талаар хангуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

6. Конторын барилгын материал худалдан авсан иргэдийн тооцоог яаралтай дуусгахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### 5.3 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Мөнххайрхан сумын ИТХ-ын 2018 оны 7/04 дугаар тогтоол, 2019 оны 9/05 дугаар тогтоолуудаар тус тус ОНХСангийн хөрөнгөөр 2019 онд 22 ажил, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 103883.5 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 22 ажил, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 103883.5 мянган төгрөгийг зарцуулж, дансны үлдэгдэлгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

ДД	Нэр	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих	Гүйцэтгэл	Зөрүү
1	Хүүхдийн тоглоомын талбай /дээд/	10000.0	10000.0	10000.0	0.0
2	Хүүхдийн тоглоомын талбай /доод/	10000.0	10000.0	10000.0	0.0
3	Луузангийн давын амны мотоциклийн гүүр	2000.0	2000.0	2000.0	0.0
4	Хөх сайгийн амны мотоциклийн гүүр	1500.0	1500.0	1500.0	0.0
5	Орон нутгийн зам засах	419.5	419.5	419.5	0.0
6	Дунд сэнхэрийн гүүр засварлах	5065.5	5065.5	5065.5	0.0
7	Гудамжны тохижилт ширнлтүүлэг хаягжуулалт	9520.0	9520.0	9520.0	0.0
8	Сурын талбай тохижуулах	4756.8	4756.8	4756.8	0.0
9	Доод лагерийн тоглоомын талбайн гэрэлтүүлэг	500.0	500.0	500.0	0.0
10	Цэцэрлэгийн гадна тохижилт	2000.0	2000.0	2000.0	0.0
11	Гудамжны хаягжуулалт	840.0	840.0	840.0	0.0
12	Ахмадын байрны тохижилт	3311.6	3311.6	3311.6	0.0
<b>ДЭД БҮТЭЦ ДҮН</b>		<b>49913.4</b>	<b>49913.4</b>	<b>49913.4</b>	<b>0.0</b>
1	Сургуулийн камер	3000.0	3000.0	3000.0	0.0
2	Хогны трактор	7700.0	7700.0	7700.0	0.0
<b>Тоног төхөөрөмж дүн</b>		<b>10700.0</b>	<b>10700.0</b>	<b>10700.0</b>	<b>0.0</b>
1	Малын үйлдэр угсааг сайжруулах	4500.0	4500.0	4500.0	0.0
2	Болзошгүй зардал	5000.0	5000.0	5000.0	0.0
3	МЭУСАХ	20438.2	20438.2	20438.2	0.0
4	Аврага хөтөлбөр	3500.0	3500.0	3500.0	0.0
5	ИТХ-ын Төлөөлөгч хөтөлбөр	2657.9	2657.9	2657.9	0.0
6	Залуучуудыг дэмжих хөтөлбөр	2000.0	2000.0	2000.0	0.0

7	Сум суртчилах. Яруу найргийн наадам	3674.0	3674.0	3674.0	0.0
					0.0
8	Номын гэгээ хөтөлбөр	1500.0	1500.0	1500.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>103883.5</b>	<b>103883.5</b>	<b>103883.5</b>	

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлуудаас хүүхдийн тоглоомын талбайнууд, сурын талбай, тоглоомын талбайн гэрэлтүүлэг, сургуульд хэрэгжүүлсэн номын гэгээ хөтөлбөр, камержуулалт, цэцэрлэгийн гадна тохижилт зэрэг ажлуудыг газар дээр нь очиж үзэхэд бүх ажлууд хийгдсэн байна. Хүүхдийн тоглоомын талбай /доод/-н ажлын цементэн талбай захаасаа эмтэрсэн, тоглоомын талбайн тайлбайн голд хагарч цоорсон байгааг дахин засварлах ажлыг хийхийг гүйцэтгэгчид болон ашиглагч нарт зөвлөж ажиллаа.

ОНХС-н санхүүгийн байдлын тайланд нийт 136.5 сая төгрөгийн авлагатай байна. Авлагын талаар дэлгэрүүлж үзүүлбэл:

1. 2013 оноос хэрэгжүүлсэн малжуулах төсөлд 4 багийн 12 малчинд 2 жилийн хугацаатайгаар 274 хонь, 303 ямаа нийт 574 толгой малын үнэ 49.9 сая төгрөг
2. 2016 онд иргэн Батхүүгийн тоолуур багцлалтын 10.4 сая төгрөг
3. 2016 онд Нью Зэст компаний бетон замын 57.8 сая төгрөг
4. 2016 онд Богос олонбулаг компани амралтын газар төсөлд 18.4 сая төгрөгийн авлагагууд бүртгэлтэй байна.

Өмнөх шалгалтын талаар:

2019 оны Санхүүгийн тайлангийн аудитаар ард иргэдээс санал аваагүй төлөөлөгч хөтөлбөрт 2.6 сая төгрөг зарцуулсанд зөвлөмж өгч, 2016 онд ОНХС-аас хэрэгжүүлсэн сумын төв гудамжинд цементэн хучилттай 78.0 сая төгрөгийн өртөгтэй бетонон замын ажлыг одоо болтол хүлээн аваагүйд албан шаардлага өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Өмнөх санхүүгийн жилүүдэд хийсэн хөрөнгө оруулалтын 3 ажлын ихээхэн хэмжээний авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг
2. 2019 онд орон нутгийн иргэдийн санал аваагүй ахмадын байрны тохижилт, сургуулийн камержуулалт, ИТХ-ын төлөөлөгч хөтөлбөр, Залуучуудыг дэмжих хөтөлбөр, сум сурталчилах, яруу найргийн наадам зэрэг дэд бүтэц, хөтөлбөрийн 5 арга хэмжээг 14643.5 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн



60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтын 6.4.1 дэх заалтыг

3. Тус сангаас хэрэгжүүлсэн малын үүлдэр угсааг сайжруулах төслийн хүрээнд Увс аймгийн Түргэн сумын Элит удам ХХК-аас 40 толгой хурган хуцыг 4000.0 мянган төгрөгөөр худалдан авч малчдад тараасан бөгөөд тайлант онд мөнгийг нь буцаан аваагүй, уг авлагыг 2019 оны жилийн эцэст тайлан балансад тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтыг тус тус зөрчжээ.

Дээрх зөрчилтэй холбоотой нийт 18643.5 мянган төгрөгийн зөрчил илэрч үүнээс 4000.0 мянган төгрөгийг сумын төсвийн орлогод оруулах улсын ахлах байцаагчийн 1 акт үйлдлээ.

#### Дүгнэлт:

ОНХСангаас 2019 онд хийгдсэн ажлын дийлэнх нь 10.0 саяаас доош ажлууд хийгдсэн ба хөрөнгө оруулалт, засварын ажил, тоног төхөөрөмж худалдаж авах зэрэг ажлуудад шууд худалдан авалтын гэрээ байгуулан санхүүжүүлж ажилласан байна.

Хөтөлбөр нэрээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг сумын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд зарцуулж байгаа нь төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.1, 60 дугаар зүйлийн 60.4 дэх заалтуудыг зөрчиж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.1.4 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч эрэмбэлэгдсэн ажлуудад оновчтой төлөвлөж, зарцуулаагүй байна.

#### Цаашид авах арга хэмжээний талаарх санал:

1. Малжуулах хөтөлбөрийг хэдий хугацаанд үргэлжлүүлэх талаар бодлогын арга хэмжээ авч, авлага барагдуулж санхүүгийн хариуцлагатай ажиллах.

2. 2016 онд ОНХС-аар хийгдсэн авлагад бүртгэлтэй байгаа хөрөнгө оруулалтын 2 ажлын талаар уг хөрөнгийг орлого авах аймгийн ИХ-ын тогтоол гаргуулж авлагаа барагдуулж ажиллах.

3. ОНХС-ын журмын дагуу иргэдийн санал авсан ажлуудыг санхүүжүүлж ажиллах. Хөтөлбөр нэрээр удирдлагыг хэрэгжүүлэх зардал гаргахгүй байх.

4. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, авлага өр төлбөрийг үнэн зөв тусган тайлагнаж байх.

Актын төлбөрийг 2020 оны 11 сард багтаан төлүүлж, биелэлтийг 2020 оны 11 сарын 25-ны дотор албан бичгээр гаргаж ирүүлэх.

#### 5.4 Сум хөгжүүлэх сангийн талаар

Засгийн газрын 153-р тогтоолын дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн зээлийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг Засаг даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-ын ажилтнаар ахлуулан, 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулан ажиллаж байна.

Мөнххайрхан сумын Сум хөгжүүлэх сангийн зээлийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрээр 17 иргэнд 43000.0 мянган төгрөг олгожээ. СХС-ын дансны орлого зарлагын гүйлгээг харуулбал:

ДД	Зардлын зүйл	Дүн	Тайлбар
1	Харилцахын эхний үлдэгдэл	12972564	
Зардлын дүн		53740450	
1	Сум хөгжүүлэх сангаас олгох зээл	43000000	Сумын ИТХ хурлын 2018.12.20-ны 7/04 дугаар тогтоолын хавсралтаар баталсан.
2	Сангийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналанд хяналт тавих зардал	396450	
3	Өвс тэжээлийн үнэ	10344000	
Санхүүгийн эх үүсвэр		55702500	
1	Зээлийн эргэн төлөлт	44967213	
2	Зээлийн хүүгийн төлөлт	1890687	
3	Өвс тэжээлийн үнэ	6969000	
4	Бэлчээрийн эрсдлийн сан	1725600	
5	Орчны бүс	150000	
5	Дансны үлдэгдэл	14934614	

Сум хөгжүүлэх сангийн дансны 2019 оны эхний үлдэгдэл 12972.6 мянган төгрөг байсан бол зээл, зээлийн хүүгийн болон бусад орлогоор 46857.9 мянган төгрөг, бусад орлогоор 8844.6 мянган төгрөг бүрдүүлж, 17 хүнд 43000.0 мянган төгрөгийн зээл олгож, өвс тэжээлийн үнэнд 8694.6 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлттэй холбоотой бичиг хэрэг, шатахуун, натриодын хураамжид 396.5 мянган төгрөг зарцуулж, дансны үлдэгдэл 14934.6 мянган төгрөг байна.

Тайлангийн жилд 17 иргэнд 43000.0 мянган төгрөгийн зээл олгосноос 7 иргэнд сүү цагаан идээ болвсруулахаар, 2 иргэн оёдолын чиглэлээр олгосон нь нийт төслийн 53% нь зөвхөн энэ чиглэлээр олгожээ.

2019 оны байдлаар зээлийн 179.6 сая төгрөгийн зээлийн авлагатай үүнээс хугацаа хэтэрсэн 30 иргэний 63.5 сая төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн

35.4%-ийг эзэлж байна. Дээрх зээлийн авлагыг бууруулах чиглэлээр Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу 2019 онд хууль шүүхийн байгууллагад хандаж, 11 иргэний 36.1 сая төгрөгийн зээлийг төлүүлэхээр нэхэмжлэл гаргасан байна.

Шүүхээс гарсан шийдвэрийн талаар доорхи хүснэгтээр харуулбал:

Мян.төгрөгөөр

Д/д	Зээлдэгчийн нэрс	Төслийн нэр	Мөнгөн дүн			Тайлбар
			Зээл	Алданги	Хүү	
1	Р.Лутаа	Буриад гутал-2014 он	3000.0	570.0	0	Шүүхийн 2019.12.10 153/ШШ2019/00587
2	Ж.Пүрэвдорж	Модон тавилга-2015 он	2500.0	663.4	51.4	Шүүхийн 2019.12.04 153/ШШ2019/00571
3	С.Мөнхтөр	Суран эдлэл-2015 он	1350.0	576.1	21.6	Шүүхийн 2020.01.06 153/ШШ2020/00006
4	Д.Цэндалтай	Шахмал түлш-2014 он	642.3	0	0	Шүүхийн 2020.04.06 153/ШШ2020/00215
5	Э.Чойжилсүрэн	Блок хийх-2015 он	662.3	0	0	Шүүхийн 2020.04.23 153/ШШ2020/00277
6	У.Хандмаа	Блок хийх-2015 он	743.3	0	0	Шүүхийн 2020.04.23 153/ШШ2020/00006
7	О.Баярхүү	Авто засвар-2015 он	1994.9	522.2	13.5	Шүүхийн 2020.04.23 153/ШШ2020/00278
8	Бөхболд /Б.Эрдэнэжаргал/	Өлөнгийн цех-2013 он	5000.0 2000.0	3600.0 0	32.3 0	Шүүхийн 2020.01.17 153/ШШ2020/00015
9	Ц.Ганбат Эрэн сурвалжилсан	Блок-2013 он	16000,0	13440.0	0	Шүүхийн 2020.04.08 153/ШШ2020/00246
10	Ц.Жаргалдалай	Борц-2015 он	4000.0		30.0	Шүүхийн 2020.04.06 153/ШШ2020/00213
11	Э.Шагдарсүрэн	Блок-2014 он	218,6	52,5	0	Шүүхийн 2020.04.06 153/ШШ2020/00214
ДҮН			21892.8	19371.7	148.8	

#### Өмнөх шалгалтын талаар:

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сум хөгжүүлэх сангаас гэрээний хугацаа дууссан 39 зээлдэгчийн 81.7 сая төгрөг, графикийн дагуу төлөлт хийгээгүй 15 зээлдэгчийн 7.6 сая төгрөг, эдгээрээс 12 зээлдэгчийн 26.4 сая төгрөгийг шүүхийн байгууллагад шилжүүлснийг нэн даруй хөөцөлдөж зохих санд төвлөрүүлэх шаардлага байгааг зөвлөсөн байна.

Санхүүгийн хяналт аудитын албанаас 2019 онд хийсэн хяналт шалгалтаар 2013-2016 оны хугацаа хэтэрсэн 14 иргэний 27023.8 мянган төгрөгийн зээлийн алдангид 7275.8 мянган төгрөгийн акт тогтоож, актыг авлага, данс бүртгэлд тусгаагүй, барагдуулаагүй байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Сангаас авсан зээлийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлдөггүй, ажил хариуцсан ажилтан нь хугацаа хэтэрсэнд алданги бүрэн тооцоогүй нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 1.6, 1.7, 4.7 дахь заалтыг

2. Зээлийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь 2-3 төрөлд жил бүр давтан зээл олгосон, хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй, сум хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд нийцүүлэн жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зориулалтын дагуу, үр ашигтай бүрэн зарцуулаагүй, сангаас зээл авсан иргэд нь тогтмол үйл ажиллагаа явуулахгүй байгаа, ажлын байр улирлын шинжтэй байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3.1, 4.3 дэх заалтыг, Сумын ИТХ-ын 2016 оны 7 дугаар сарын 26 дугаар тогтоолын хавсралтыг

3. 2018 онд тус сангаас нь 8 иргэний хугацаандаа төлөөгүй 4900000 төгрөгийн зээлд 1725000 төгрөгийн алданги тооцож төлүүлээгүй нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 1.7, 4.7 дахь заалт, Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээний 2.3, 5.5 дахь заалтыг

4. 2016-2018 онуудад зээл авсан зээлдэгч нарын хугацаа хэтрүүлсэн зээлд алданги тооцсон актын төлбөрийн 7.2 сая төгрөгийг СХС-ын авлагаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлийг

5. 2019 онд татан авсан, борлуулсан өвс тэжээлийн тооцоо бодоогүй, 3055060 төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй явж ирсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлийг тус тус зөрчжээ.

Шалгалтын хугацаанд бэлэн байх ёстой 820 ш пресс өвс шатсан гэх тайлбар хийж байгаа бөгөөд Цагдаа, Онцгой байдлын газарт хандсан бөгөөд галын дүгнэлт гараагүй байгаа тул яаралтай энэ асуудлыг шийдвэрлэж, төрийг хохиролгүй болгох талаар хуулийн хүрээнд ажиллахыг зөвлөлөө.

Дээрх зөрчилтэй холбоотой 4780060 төгрөгийн зөрчил илрүүлж, Сум хөгжүүлэх сангийн дансанд авлагаар бүртгэж, орлогыг сангийн дансанд яаралтай оруулахыг зөвлөж улсын байцаагчийн 2 акт үйлдлээ.

Дүгнэлт:

2019 онуудын сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих орон тооны бус зөвлөл нь зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлтийн байдалд тавих хяналт сул байна.

Цаашид авах арга хэмжээний талаарх санал:

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийг гэрээний дагуу төлүүлж, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээний дагуу алданги тооцож, данс бүртгэлд авлагаар бүрэн тусгаж байх.

2. Сангийн хяналтын болон сонгон шалгаруулах зөвлөлийг журмын дагуу ажиллуулж, сангийн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах.

3. 2019 онд СХАА-аас тавьсан актыг данс бүртгэлд авлагаар тусгах.

4. СХС-аар хийгдэж байгаа өвс тэжээлийн тооцоог хариуцсан нэг эзэнтэй болгож, авлагыг НББ-д бүрэн тусгаж байх. Мөн СХС-ын зээлийн хувийн хэрэг, зээлтэй холбоотой бүх баримт бичиг, тайлан тооцоог нэг ажилтанд хариуцуулж ажиллах.

5.5 Ерөнхий боловсролын сургууль

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус сургууль нь 2019 онд улсын төсвөөс 691727.0 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 691727.0 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 1500.0 мянган төгрөг, “Багшийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд Боловсрол соёлын газраас 7369.2 мянган төгрөг, Мобиком, Юнитель ХХК-аас түрээсийн орлогоор 2410.0 мянган төгрөг, нийт 14827.2 мянган төгрөг бүрдүүлэн бараа үйлчилгээний зардалд 10917.0 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 1500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 2410.0 мянган төгрөгийг төсвийн төвлөрүүлэн захирагчид шилжүүлсэн байна.

2019 онд цалингийн зардалд 533012.8 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 66626.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 27272.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 511.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1415.8 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 508.3 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 312.5 мянган төгрөг, хог хаягдал устгах цэвэрлэх зардалд 190.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардалд 953.5 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэлийн зардалд 255.1 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 35459.1 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1252.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1991.5 мянган төгрөг,

томилолтын зардалд 257.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 183.6 мянган төгрөг, хичээл сургалт үйлдвэрийн зардалд 12974.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3192.5 мянган төгрөг, үдийн цайны зардалд 16273.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 1500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Тус байгууллага 2019 оны эхэнд авлагагүй байсан бол жилийн эцэст 378.7 мянган төгрөг болж, авлага 378.7 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн эхний үлдэгдэл 815.8 мянган төгрөг байсан бол оны эцэст 4416.6 мянган төгрөг, болж 3600.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө 2019 оны эхэнд 1484486.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 1486901.7 мянган төгрөг болж, 2415.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Тавилга, эд хогшил 2415.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Өмнөх шалгалтын талаар:

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хүүхдийн хоолны зардлыг батлагдсан зардлаас илүү тооцон зарлага болгосон, анхан шатны баримт болох цалингийн хүснэгтэд гарын үсэг зуруулаагүй, жилийн эцэст няравын тооцоо болон нүүрсний тооцоог бодоогүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны санхүүгийн хяналт шалгалт 2019 оны 09 сарын 30-ны өдөр хийгдэж илүү олгосон кабинетийн нэмэгдэл төлүүлэх тухай нэр бүхий 4-н багшид 505789 төгрөгийн, мэргэжлийн зэргийн нэмэгдэл төлүүлэх тухай 330324 төгрөгийн, утасны нэгжний үнэ төлүүлэх тухай 64700 төгрөгийн улсын ахлах байцаагчийн акт тус тус тавигдаж актыг бүрэн барагдуулсан байна.

#### Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2019 онд дотуур байрны хүүхдийн хоолны талонд хүнсний материалыг хоолны зардлын нормативээс хэтрүүлэн 359344 төгрөгийн материалыг тус тус илүү тооцон зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 13.7 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолыг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг

2. 2019 онд сургуулийн захирлын тушаалаар сахилгын шийтгэлтэй байхад багш Э-д 354052 төгрөгийн, Ц-д 134000 төгрөгийн, нийт 488052 төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл цалин илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.3 дахь заалтыг

3. 2019 оны 07-08 саруудад жолооч М-д ажил хавсарсны нэмэгдлийг 90909 төгрөгөөр цагийн бүртгэлээс илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 13.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дэх заалтууд, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.2 дахь заалтуудыг

4. Тус сургууль нь пургон маркийн авто машинтай ба 2019 онд шатахууныг байгууллагын болон хувийн машинд зарцуулснаар замын хуудас болох анхан шатны баримт бүрдүүлсэн боловч машин хуучирсан шалтгаанаар нормативыг мөрдөж тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг

5. 2019 онд хугацаа дууссан, хүчингүй үнэмлэхээр Сургуулийн тогооч О-д 237327 төгрөг, Ц-д 226323 төгрөг, нийт 463650 төгрөгийг тогоочийн зэргийн нэмэгдэлд илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дэх заалтууд, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 5-р хавсралтын 4 дэх заалтыг

6. Шалгалтаар тус сургуулийн хөрөнгийг хэсэгчлэн тоолоход багш С нь тус сургуулийн данс бүртгэлд байгаа хөрөнгө болох Lenovo маркийн MPO9K9SL кодтой 1183860 төгрөгийн үнэ бүхий нөүтбүүк болон 400000 төгрөгийн үнэ бүхий өнгөт принтерийг ажлаас гарахдаа хүлээлгэн өгөөгүй, 2019 онд хийсэн шалгалтаар зөвлөмж, шаардлага хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл тус сургуульд хүлээлгэн өгөөгүй, сургалтын менежерээр ажиллаж байсан О нь өөрийн эзэмшиж байсан сургуулийн данс бүртгэлд байгаа DELL маркийн 880000 үнэ бүхий нөүтбүүкийг ажлаас чөлөөлөгдөхдөө тус тус хүлээлгэн өгөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.1, 73 дугаар зүйлийн 73.1.4 дэхь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 132 дугаар 132.1 дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шалгалтаар 12 жилийн сургуульд нийт 3865815 төгрөгийн зөрчил илрүүлж, 3865815 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

Дүгнэлт:

Тус сургууль нь санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, зөрчилгүй санал дүгнэлттэй тушааж хэвшсэн ба анхан шатны баримтын бүрдэл, нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байна.

Шатахууны зардлыг хэтрүүлэн гүйлгэн зарцуулсан ба анхан шатны баримт болох замын хуудсаар жолоочийн тооцоог нарийвчлан тооцож бодоогүй, хүүхдийн хоолны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулсан, цалин тэтгэмж олгохдоо хууль эрх зүйг зарим тохиолдолд мөрдөөгүй байна.

#### Цаашид авах арга хэмжээний санал:

1. Бараа материал, шатахууны тооцоог сар, улирал бүр хийж хэвших, анхан шатны баримт бүрдээгүй ажил гүйлгээг хийхгүй байх, Бараа материалын тайланг стандартын дагуу үнэн зөв гаргах, НББОУС, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжинд нийцүүлэн бэлтгэх.

2. Сахилгын шийтгэлтэй хугацаанд багш ажилтанд үр дүн, урамшуулал олгохгүй байх.

3. Дотуур байрны хүүхдийн хоолны талонд хүнсний материалыг байрны хүүхдийн ирцийн бүртгэл, хоолны зардлын нормативээс хэтрүүлэн зарцуулахгүй байх.

4. Сургуулийн 2 тогоочид зэргийн нэмэгдэл олгохыг зогсоож, зэргийн сургалтанд сууж хугацаа сунгасан тохиолдолд олгох.

5. Цалин хөлсийг бодож олгохдоо цагийн тооцоо, тушаал шийдвэрт үндэслэн үнэн зөв олгож хэвших.

6. Ажил хүлээлцэх комисс нь ажлаас чөлөөлөгдөж байгаа багш, ажилчдыг эцсийн тооцоо хийж, үндсэн хөрөнгө болон хариуцаж байсан хөрөнгийг бүрэн хүлээж авсны дараа чөлөөлөх.

#### 5.6 Хүүхдийн цэцэрлэг

##### Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Тус байгууллага нь 2019 онд улсын төсвөөс 242788.0 мянган төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 272560.5 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна. Төсвийг 29772.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын Тамгын газраас эрх шилжсэн засварын санхүүжилт орсонтой холбоотой байна.

Тус онд цалингийн зардалд 165760.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 20545.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11271.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 716.2 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 762.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 164.2 мянган



төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсэд 142.3 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэлд 41.9 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 30219.6 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 396.2 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1936.4 мянган төгрөг, томилолтын зардалд 80.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 108.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2422.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 780.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 37905.2 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Оны эхэнд 47.9 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацааны эцэст 367.1 мянган төгрөг болж, 319.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Оны эхэнд өглөггүй байсан бол тайлант хугацааны эцэст 1807.3 мянган төгрөгийн өглөгтэй болсон байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 235594.7 мянган төгрөг байсан бол оны эцэст 273812.5 мянган төгрөг болж, 38217.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 36402.2 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авсан байна. Мөн тайлант онд 9556.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулж, 46038.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй болсон байна.

#### Өмнөх шалгалтын талаар:

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

#### Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:

Шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. Цэцэрлэгийн 2019 оны зарим өдрийн хүүхдийн хоолны цэсийг зөрчиж, цэсэнд байхгүй хоол хүнсний материал болох цагаан будаа, үхрийн мах зэрэг 178000 төгрөгийн хүнсний материалыг хүүхдийн хоолны талоноор зарлага болгосон нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалын хоёрдугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг

2. 2019 онд хүүхдийн хоолны талонд 636905 төгрөгийн хүнсний материалыг хоолны зардлын нормативаас хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.4.1 дэх заалтууд, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дэх заалтууд, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтуудыг

3. 2019 оны 06 дугаар сард Дуу хөгжмийн багш Э-д амралтын цалин дээр 6 сарын цалингийн цагийн тооцонд ороогүй 11 өдрийн цалин 476106 төгрөгийг тушаал шийдвэргүй, ажиллаагүй байхад олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалт, Хөдөлмөрийг тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4. 2019 оны 02 дугаар сарын 28-нд 151600 төгрөг, 11 дүгээр сарын 13-ний өдрийн 71200 төгрөгийн төлбөрийн хүсэлт болон санхүүгийн баримтанд цэцэрлэгийн эрхлэгчийн болон, төрийн сангийн тамга тэмдэг гарын үсэг дутуу үйлдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалтууд, Төрийн сангийн төлбөр тооцооны журамын 7.5, 7.6, 7.7 дахь заалтыг тус тус зөрчжээ.

Шалгалтаар нийт 5 хүнтэй холбоотой 1513811 төгрөгийн зөрчил илрүүлж, 1291011 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар шийдвэрлэж улсын байцаагчийн акт тогтоож, 222800 төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгч шийдвэрлэв.

#### Дүгнэлт:

Нярав хүнсний тайлан буруу гаргасан, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгодог, нярав эрхлэгч нар агуулахын үлдэгдэлийг баталгаажуулж ажиллаагүй байна.

#### Цаашид авах арга хэмжээний санал:

1. Хүүхдийн хоолны нормд тааруулж, батлагдсан хоолны цэсний дагуу хоол үйлдвэрлэл явуулах ба хүүхдийн хоолны цэсэнд орсон хоолны материалыг зарлага болгож хэвших.

2. Туслах тогоочийг мэргэжлийн сургалтанд хамруулах, мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгож байгааг зогсоох.

3. Санхүүгийн анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, анхан шатны баримт бүрдээгүй гүйлгээг хийхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах

#### 5.7 Соёлын төв

#### Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2019 онд улсын төсвөөс 67821.4 мянган төгрөг, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөг, нийт 68821.4 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж гүйцэтгэлээр санхүүжилтээр 67821.4 мянган төгрөг өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөг олж, бүгд 68821.4 мянган төгрөгийн зардал гаргаж үйл ажиллагаа явуулжээ.

Гарсан зардлаас: цалинд 51413.4 мянган төгрөг, НДШ-д 6426.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 6829.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 75.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 186.5 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 52.5 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 60.0 мянган төгрөг, томилолтонд 47.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 282.0 мянган төгрөг, урсгал засварт 254.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 2637.0 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 110.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

2019 оны эхэнд авлагагүй, 425.6 мянган төгрөгийн түлш халаалтын өглөг үүссэн байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 170883.8 мянган төгрөг байснаа 171400.8 мянган төгрөг болж 517.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Орон тоо 7 ажилтантайгаар батлагдаж, 2019 онд 7 орон тоотой ажиллаж иржээ.

Өмнөх шалгалтын талаар:

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар: “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Эрхлэгч М-д 2019.01.25-ны өдрийн А/05 тоот захирамжаар ур чадварын нэмэгдлийг 3 сараар 20 хувь , 2019.06.21-ний өдрийн А/86 тоот захирамжаар 5, 6 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 3 сараар 20 хувь тус тус захирамж гарсан байхад 4 дүгээр сарын цалингийн цэсэнд нэмэгдэл /5 дугаар сард олгоогүй боловч суутган тооцохоор бүртгэлд тусгаагүй./ олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.6 дахь заалтыг

2. 2019.09.02-ны Б/11, Б/12 тоот тушаалаар галчийг 9.02-ны өдрөөс ажиллуулсан, 2019 оны 9 дүгээр сард ажлын 20 хоногтой галлагаа эхлээгүй байхад эрх зүйн актгүй засварын ажил хийлгэж, үндсэн цалинг бүтэн олгосон /галлагаагүй хугацаанд галч нартай гэрээ байгуулж гэрээтийн цалингаар цалинжуулж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах. 432754-320000/ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 16.5.6 дахь заалт, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 ,5.2.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018.08.19-ний 05 дугаар тогтоолыг

3. 2019 оны 12 дугаар сард 3 галчид нийт 95 илүү цаг олгосон, ажлын 22 өдрөөс 9 өдөр нь нийтээр амрах амралтын хоногтой байхад 40, 31, 24 цагаар тус тус илүү цаг олгосон  $95-72 = 23/3 = 7.66$  нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.6 дахь заалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 53.1, 54.1 дэхь заалтыг

4. 2019.01.03-ний Б/01 тоот соёлын төвийн эрхлэгчийн тушаалаар үйлчлэгчийг ажлаас чөлөөлсөн байхад 3 өдрийн цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалтыг

5. 2019 оны 12 дугаар сард соёлын төвийн номын санч, нярав албан тушаалтай С-ийн гаргасан түлш шатах тослох материалын тайланд нүүрсний үлдэгдэл 19 тн нэгжийн үнэ 120.0 мянган төгрөг, аргал 2.3 тн нэгж үнэ 120.0 мянган төгрөг буюу нийт 22560.0 мянган төгрөгийн тайлан гаргасан байхад нягтлан бодогчийн тайланд 2460.0 мянган төгрөгөөр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.6 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дэхь заалтыг

6. 2019 оны 12 дугаар сард кассаар няравын дансаар дамжуулан Уран бүтээлийн зардлаас анхан шатны баримтгүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.6 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дэхь заалтыг

7. Уран бүтээлийн зардлаас гаргасан 500,0 мянган төгрөгийн хөрөнгө нь няравын бараа материалын тайланд анхан шатны баримтгүй, тусгагдаагүй байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалтуудыг

8. 2019 оны жилийн хэмжээнд 444366 төгрөгийн шатахууны гүйлгээг анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шалгалтаар нийт 1330727 төгрөгийн төлбөр зөрчил илэрч 845134 төгрөгийг зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвөлгөө өгч, 290314 төгрөгийг төлүүлж, орон нутгийн төсвийн орлогод оруулахаар тус тус шийдвэрлэж улсын ахлах байцаагчийн 3 акт тогтоосон байна.

#### Дүгнэлт:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, тайлан балансаа хуулийн хугацаанд гарган тушааж, санхүүгийн зөрчилгүй дүгнэлттэйгээр

ажиллаж ирсэн боловч нярав нягтлан бодогчийн тайлан зөрүүтэй түлш нүүрсний тайлан орлого авч шаардах хуудас зарлагын паданаар тайлан гаргаагүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Санхүүгийн жилд үүссэн өр, авлагыг барагдуулах, хойшид авлага, өр төлбөр үүсгэлгүй санхүүгийн хариуцлагатай ажиллах.

2. Бараа материал, бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, шатахууны тооцоог сар, улирал бүр хийж хэвших, төсвийн байгууллагад зарцуулж байгаа нүүрсийг олгосон жагсаалтыг өдөр бүр үйлдэж тооцоо хийх, анхан шатны баримт бүрдээгүй ажил гүйлгээг хийхгүй байх, Бараа материалын тайланг стандартын дагуу үнэн зөв гаргах, НББОУС, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжинд нийцүүлэн бэлтгэх.

3. Төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан санхүүгийн жилийн эхэнд тогтоон, мөрдөж ажиллах, ур чадварын болон бусад нэмэгдэлийг тусгайлан захирамж, тушаалаар нэр хувь хэмжээг тодорхой зааж гаргах

4. Төсвийн хэмнэлтийг зориулалтын дагуу төвлөрүүлэн зарцуулах ба өр авлага үүсгэж өөр зардалд шилжүүлдэг асуудлыг таслан зогсоох, төсвийн үрэлгэн байдал гаргахгүй байж, 2014 оны Засгийн газрын 147 дугаар тогтоолыг мөрдөж хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллах.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөх, төрийн өмч бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тушаал шийдвэргүйгээр аливаа хөрөнгө борлуулах, данснаас хасахгүй байх.

6. Үнэт цаасны тооцоо, түлшний тайлан шатахууны тооцоог сар улирлаар хийж, орлогын тооцоог бодож баталгаажуулах.

5.8 Эрүүл мэндийн төв:

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2019 онд улсын төсвөөс 339820.8 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 339820.8 мянган төгрөгийн төсөв бүрдүүлэн зарцуулсан байна.

Цалингийн зардалд 235041.8 мянган төгрөг, НДШ-д 29380.2 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2487.2 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 10697.7 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 446.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 2300.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 17458.2 мянган төгрөг, шуудан холбоо, интернэтийн зардалд 1400.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгалын зардалд 2500.0 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 29473,6 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 7248.8 мянган

төгрөг, нормын хувцасны зардалд 3500.0 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 4000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2452.6 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 1200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 19323.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 6225.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Авлага 2019 онд онд авлагагүй, өглөг оны эцэст 6069.6 мянган төгрөгийн эмийн өглөгтэй болсон байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 382624.9 мянган төгрөг байснаа 404746.9 мянган төгрөг болж 22122.0 мянган төгрөгөөр өссөн байна. Машин тоног төхөөрөмж 21063.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 602.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон тоо 21 ажилтантайгаар батлагдаж 2019 онд 22 орон тоотой ажиллаж эм зүйчийг ажиллуулж ирсэн байна.

#### Өмнөх шалгалтын талаар:

2019 онд Төрийн аудитын байгууллагаас тус байгууллагын санхүүгийн тайланд “Итгэмжлэл” олгосон байна.

#### Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар:

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

1. 2019 оны жолоочийн шатахууныг түүвэрчлэн үзэхэд замын хуудсанд явсан километр шатахуун илүү тооцож бичсэн, хэрэглэгчийн гарын үсэггүй, нийт 1295917 төгрөгийн шатахууныг жолоочийн тооцоо, замын хуудсаар албаны машинд зарлага болгосон боловч дуудлагын журналд байхгүй 2019 оны алсын дуудлага журналд том хүн 74, хүүхэд 84 өвчилсөн дуудлага байхад статистик дүн мэдээнээс зөрүүтэй, 96482 төгрөгийн шатахууныг зориулалт бус, анхан шатны баримтгүйгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалыг

2. 2019 онд тендерийн эм, эргэлтийн эмийн сан, ЭМГ-аас эмийн авлагагүй, бусад зардлын тооцооны авлагагүй, 6069663 төгрөгийн өр төлбөртэй, тендерийн нийт эмийн үлдэгдэл тайланд 6175310 төгрөг байхад 1270168 төгрөгийг шууд зардалд тусгасан, 2019 оны 12 дугаар сарын байдлаар тендерийн эмийн агуулахын үлдэгдэл тооллогын комиссоор 7445478 төгрөгний үлдэгдэлтэй, бага үнэтэй түргэн элэгдэх төрөхийн эм боох болон ариутгал бодис нэг удаагийн тайланг эмийн тайланд тусгаагүй, шаардахаар зарлагдаагүй, шууд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалтуудыг

3. Ээлжийн амралттай байх хугацаанд үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан ажилласан хугацаанаас илүү тооцож А,В,С үнэлгээг авсан оноонд харгалзуулан тооцоогүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.5 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолын Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журмын 2 дугаар зүйлийн 2.10 дахь заалт, Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, байгууллагын дотоод журам хамтын гэрээг зөрчиж байна.

Дээрх зөрчлүүдтэй холбоотой нийт 15 хүн байгууллагтай 2365736 төгрөгийн зөрчил илэрснээс 1095568 төгрөгийн орон нутгийн төсвийн орлогод, 1270168 төгрөгийг тухайн байгууллагын төсөвт орлого авахуулж данс бүртгэлд тусгуулахаар шийдвэрлэж, улсын байцаагчийн 4 акт тогтоолоо.

#### Дүгнэлт:

2019 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт суларсан, бараа материалын тайлан нэн ялангуяа эмийн тайлан, өвчтөний хоол, шатахуун, түлш, бичиг хэргийн материал урсгал зардлын тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдэлт, няравын тайлан гаргалт хангалтгүй байна.

#### Цаашид авах арга хэмжээний санал:

1. Санхүүгийн жилд үүссэн өр, авлагыг барагдуулах, хойшид авлага, өр төлбөр үүсгэлгүй санхүүгийн хариуцлагатай ажиллах.

2. Төсвийн байгууллагуудад зарцуулж байгаа нүүрсийг өдөр бүр олгосон жагсаалт үйлдэж, шатахуун болон нүүрсний тайлан, бараа материал, бичиг хэргийн зардлыг сар улирлаар гаргаж хэвших.

3. Төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан санхүүгийн жилийн эхэнд тогтоон, мөрдөж ажиллах.

4. Автомашинд олгож байгаа сэлбэг хэрэгсэл, дугуйн нормыг тооцох, автомашины хувийн хэргийг хөтлөх, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалуудыг мөрдөж ажиллах.

5. Ажиллагсдын илүү цаг болон нэмэгдлийг хууль эрх зүйн хүрээнд зөв тооцоолон олгож хэвших.

6. Шатахууны тайлан, жолоочийн тооцоог заавар журмын дагуу сар бүр хийж хэвших.

7. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй, дотоод хяналттай зарцуулах.

8. Шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбоотой зөрчил гаргасан ажилтнуудад ажил сайжруулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцож ажиллах.

9. Байгууллагад төлөх өглөгийг жилийн эцэст тооцоо нийлж тооцооны үлдэгдлийн баталгааны хуудсаар харилцан баталгаажуулах.

Зургаа. Мөнххайрхан сумын төсөвт байгууллагуудад хийсэн шалгалтын дүн

Шалгалтаар нийт сумын хэмжээнд 50 хүнтэй холбоотой 18.585.838 төгрөгийн зөрчил илрүүлж, 8.535.610 төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар, 4.325.228 төгрөгийг данс бүртгэлд тусгуулахаар, 5.725.000 төгрөгийг сумын төсөвт оруулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

Дүгнэлт:

Мөнххайрхан сумын төсөвт байгууллагууд, сангуудын үйл ажиллагаанаас дүгнэн үзэхэд нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчиж гар дээрээс бэлэн мөнгө зарцуулсан, жолоочийн тооцоог бүрэн хянаж бодоогүй, замын хуудсыг хангалтгүй, буруу хөтлөж байгаа, сангаас гаргасан хөрөнгийг авлагаар данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг гарч байгаа нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулж, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Төсөвт байгууллагуудад өгөгдсөн зөвлөмж, актын төлбөрийг барагдуулж тайланг албан бичгээр Санхүүгийн хяналт аудитын албанд 2020 оны 11 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг даалгав.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА